

| <b>Компанийн засаглалын үнэлгээний асуулга</b>   |   |   |  |      |      |
|--|---|---|--|------|------|
| <i>Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..</i> |   |   |  |      |      |
| <b>НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b>   |   |   |  |      |      |
| <b>ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна</b>   |   |   |  |      |      |
| №  | Зүйл  | Хэрэгжилт   | Тайлбар  | Оноо | Хувь |
| 1  | <i>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i>   | Хэрэгжүүлдэг  |  |      |      |
| 2  | <i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</i>   | КТХ-ийн дагуу зохицуулдаг байсан.   |  |      |      |
| 3  | <i>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.</i> | Хэсэгчилэн хэрэгжүүлсэн   |  |      |      |
| 4  | <i>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</i>       | ТУЗ-ийн үйл ажиллагааны журамтай  | ТУЗ-ийн гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлагыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд шинэчилэн тусгана. |      |      |
| 5  | <i>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>                                     | ТУЗ-ийн шинэ гишүүнийг холбогдох шаардлагатай мэдээллээр ханган ажилладаг |  |      |      |
| 6  | <i>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>   | ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу хариуцлага хүлээнэ                   |  |      |      |
| <b>ДҮН</b>   |   |   |  |      |      |
| <b>ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ</b>   |   |   |  |      |      |
| <b>ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ</b>  |   |   |  |      |      |

|  |  |                                    |   |  |  |
|--|--|------------------------------------|---|--|--|
| 7  | 2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.  |                                    | КТХ-ийн 75-р зүйлийн 75.4-т заасны дагуу ТУЗ нь 9 гишүүнтэй 3/2 нь хараат бус гишүүн байна.   |  |  |
| 8  | 2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.  | Хэсэгчилэн хэрэгжүүлдэг            |   |  |  |
| 9  | 2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно. | Хэсэгчилэн хэрэгжүүлдэг.           |   |  |  |
| 10   | 2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.   | Хэсэгчилэн хэрэгжүүлдэг            |   |  |  |
| 11   | 2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.  | Хэрэгжүүлэг үй                     | ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болох боломжийг ТУЗ-ийн үйл ажиллаганы журамдаа шинээр тусган оруулна. |  |  |
| <b>ДҮН</b>   |  |                                    |   |  |  |
| <b>ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ</b>  |  |                                    |   |  |  |
| <b>ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана</b> |  |                                    |   |  |  |
| 12   | 3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.   | ТУЗ нь тайлагналыг ил тод хүргэдэг | ТУЗ нь коипанийн мэдээллийн ил тод байдал, тайлангийн журмыг 2023 оны 4-р улиралд багтаан баталж мөрдүүлнэ.   |  |  |
| 13   | 3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.   | Хэрэгжүүлэн ажиллана               |   |  |  |

|   |   |                         |  |  |  |
|---|---|-------------------------|--|--|--|
| 14  | 3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.  | Хэсэгчилэн хэрэгжүүлдэг |  |  |  |
| <b>ДҮН</b>  |   |                         |  |  |  |
| <b>ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО</b>   |   |                         |  |  |  |
| <b>ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана</b>   |   |                         |  |  |  |
| 15  | 4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.  |                         | ТУЗ-ийн үйл ажиллагааны журамдаа шинэчилэн тусгаж ажиллана.                                  |  |  |
| 16  | 4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.  |                         | 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас эхлэн хэрэгжүүлж эхэлнэ.                        |  |  |
| 17  | 4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.  |                         | 2023 оны жилийн үйл ажиллагааны тайлангаар болон өөрчлөлт орсон тухай бүрт мэдээлж ажиллана. |  |  |
| <b>ДҮН</b>  |   |                         |  |  |  |
| <b>ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА</b>   |   |                         |  |  |  |
| <b>ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина</b> |   |                         |  |  |  |
| 18  | 5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.   |                         | Боловсруулж ажиллана   |  |  |
| 19  | 5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана. |                         | Бодлогын баримт бичигтэй болсоноор хэрэгжүүлж ажиллана.                                      |  |  |
| 20  | 5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.  |                         | Эдгээр асуудлаар эрсдлийн үнэлгээ хийж 2023 оны жилийн үйл                                   |  |  |

|  |  |                          |   |  |  |
|--|--|--------------------------|---|--|--|
|  |  |                          | ажиллагаандаа тайлагнаж ажиллана.   |  |  |
| 21   | <i>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>  |                          | Комплайнсын хяналтын заавар бүтцийг 2023 оны 4-р улиралд багтаан батална.   |  |  |
| <b>ДҮН</b>   |  |                          |   |  |  |
| <b>ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ</b><br>Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна |  |                          |   |  |  |
| 22   | <i>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</i>  | ТУЗ-ийн хурлаар баталдаг |   |  |  |
| 23   | <i>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.</i>  |                          | Цалин урамшууллын бодлогыг 2023 оны ээлжит бус хурлаар батлана.   |  |  |
| 24   | <i>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</i>   |                          | 2023 оны жилийн үйл ажиллагааны тайландаа тусган ажиллана.  |  |  |
| <b>ДҮН</b>   |  |                          |   |  |  |
| <b>ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ</b><br>Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ  |  |                          |   |  |  |
| 25   | <i>7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</i> |                          | ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичгийг боловсруулан баримталж ажиллана. |  |  |
| 26   | <i>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</i>  |                          | 2023 оны үйл ажиллагааны тайлангаас эхлэн уг асуудлыг тусгана.  |  |  |
| 27   | <i>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</i>  |                          | Оролцогч талуудтай харилцах бодлого батлагдсаны дараа түүнд нийцүүлэн ажиллана.   |  |  |
| 28   | <i>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг</i>   | Компанийн дотоод журмын  |   |  |  |

|   |   |  |  |  |  |
|---|---|--|--|--|--|
|   | <i>шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</i>   | дагуу хэрэгжүүлдэг.  |  |  |  |
| <b>ДҮН</b>  |   |  |  |  |  |
| <b>НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ</b>   |   |  |  |  |  |
| <b>ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно</b>  |   |  |  |  |  |
| 29  | <i>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i> |  | Боловсруулж байгаа.  |  |  |
| 30  | <i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.</i>  |  | Шинээр батлах ёс зүйн дүрэмд тусган нийтэд мэдээлнэ.   |  |  |
| 31  | <i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</i>                                   |  | Ёс зүйн дүрэмд тусган ажиллана.  |  |  |
| <b>ДҮН</b>  |   |  |  |  |  |
| <b>ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ</b>   |   |  |  |  |  |
| <b>Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана</b> |   |  |  |  |  |
| 32  | <i>9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.</i>                    | Жил болон хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаар мэдээллийг хүргүүлдэг |  |  |  |
| 33  | <i>9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</i>  |  | Цахим суваг болон Үнэт цаасны брокер деллерүүдээр дамжуулан цахим болон шуудангаар харилцаа холбоо тогтоон байгууллагын Пэйж хуудсыг идэвхижүүлэн ажиллана |  |  |
| 34  | <i>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</i>                                | Хангагдсан   |  |  |  |
| 35  | <i>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</i>  | КТХ-ийн дагуу санал өгөх эрхээ хэрэгжүүлэх эрх нь нээлттэй                               |  |  |  |
| 36  | <i>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх</i>   |  | Энэхүү журмыг баталж 2023  |  |  |

|                    |   |  |                                   |  |  |
|--------------------|---|--|-----------------------------------|--|--|
|                    | <i>зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</i> |  | оноос эхлэн дагаж мөрдөн ажиллана |  |  |
| <b>ДҮН</b>         |   |  |                                   |  |  |
| <b>НЭГДСЭН ДҮН</b> |   |  |                                   |  |  |

-оОо-